



ДААТГАЛ
SINCE 1994

Сэнтрал тауэр, 13-р давхар, 1305-1307 тоот,
Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сүхбаатарын талбай-2,
УБ- 14200, Монгол улс
Утас: 7720 0088, И-мэйл: info@arddaatgal.mn.

2025 он 4 сар 29 өдөр

Дугаар 01/25

Улаанбаатар хот

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны үйл ажиллагааны болон
санхүүгийн тайланг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9, 2025 оны 4 сарын 29-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын №2 тоот тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Ард Даатгал ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэсэн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хавсралтаар баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.БОЛОРЧИМЭГ

2025 он 4 сар 29 өдөр

Дугаар 02/25

Улаанбаатар хот

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
гишүүдийг сонгох тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7, 2025 оны 4 сарын 29-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын №3 тоот тогтоолуудыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Ард Даатгал ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр Одончимэд овогтой Одбаяр, Галням овогтой Уянга, Галбадрах овогтой Цогбадрах, Батбилэг овогтой Золбоо, Намдалдагва овогтой Эрдэнэтулга, Сүхдорж овогтой Оргил нарыг, хараат бус гишүүнээр Баатарзоригт овогтой Болорчимэг, Ганхуяг овогтой Хонгорзул, Нанзад овогтой Хосбаяр нарыг тус тус сонгохыг зөвшөөрсүгэй.
2. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн мэдээллийг Санхүүгийн Зохицуулах Хороонд хүргүүлж, зохих зөвшөөрлийг авч ажиллахыг Төлөөлөн Удирдах зөвлөлийн Нарийн бичгийн дарга (Г.Баярбат)-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.БОЛОРЧИМЭГ

2025 он 4 сар 29 өдөрДугаар 03/25

Улаанбаатар хот

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

*Компанийн дүрэм нэмэлт өөрчлөлт
оруулах тухай*

Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг, 62 дугаар зүйлийн 62.1.1 дахь хэсэг, Компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.6.1 дэх хэсэг болон 2025 оны 4 сарын 29-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын №4 тоот тогтоолуудыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Ард Даатгал ХК-ийн дүрэмд дараах өөрчлөлтийг оруулсугай.
 - 1.1. Ард Даатгал ХК-ийн дүрмийн 1.4-д “Компанийн бэлгэдэл тэмдэг нь ARD гэсэн гурван үсгээс бүрдсэн улаан өнгөтэй байх ба хажууд нь Даатгал since 1994 гэж бичсэн байна” гэж заасныг “Компани “Хүчтэй.Хамтдаа.” гэсэн уриа үгтэй байх бөгөөд Компанийн бэлгэдэл тэмдэг нь ARD гэсэн гурван үсгээс бүрдсэн улаан өнгөтэй байх ба хажууд нь Даатгал since 1994 гэж бичсэн байна” гэж өөрчлөх;
2. Ард Даатгал ХК-ийн дүрэмд дараах нэмэлтийг оруулсугай.
 - 2.1. Компанийн дүрмийн 1.6 дахь хэсэгт “Компани нь хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигч, харилцагч, үйлчлүүлэгч, ажиллагсаддаа урамшуулах зорилгоор өөрсдийн урамшуулын оноо АрдКойныг ашиглана. Энэ нь бусад хэлбэрээр урамшуулал олгохыг хориглох заалт болохгүй” гэж;
 - 2.2. Компанийн дүрмийн 1.7 дахь хэсэгт “Компани нь Хөрөнгө Оруулагч Үндэстэнг цогцлоох эрхэм зорилготой ажиллана” гэж тус тус нэмэх;
3. Энэхүү шийдвэрийн 1, 2 дахь хэсэгт заасан нэмэлт, өөрчлөлт оруулсан Компанийн дүрмийг хавсралтаар баталсугай.

4. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж хавсралтаар баталсан Компанийн дүрмийг хууль, тогтоомжийн дагуу улсын бүртгэлд бүртгүүлэх, холбогдох бусад байгууллагад хүргүүлэх ажлыг зохион байгуулахыг Гүйцэтгэх захирал (Н.Эрдэнэтулга)-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.БОЛОРЧИМЭГ